

**ХҮМҮҮНЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ  
ТАЙЛАН**

**ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, тайланг гаргав.

Төслийн үр нөлөөг үнэлэх ажлын зорилго нь Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн заалтуудад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад чиглэгдэв.

Үнэлгээг Аргачлалын 1.4-т заасны дагуу дараах үе шатын дагуу хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсгийг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгсэлийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ**

Хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд заасан үндсэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдсан байдал.

**Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл**

- Зорилгод хүрэх байдал:

Хуулийн төслийн зохицуулалт нь дэвшүүлсэн зорилго, зорилт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

- Ойлгомжтой байдал:

Хуулийн төслийн агуулга нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд ойлоход хялбараар томьёологдсон бол хэрэгжилтийн үр дүн сайн байдаг. Ийм учраас үнэлгээнд энэхүү үзүүлэлтийг сонгосон болно.

- Харилцан уялдсан байдал:

Хуулийн төслийн зүйл заалт бүр өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжийн заалтуудтай нийцсэн, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай байдаг учраас энэхүү үзүүлэлтийг сонгов.

## ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн дугаар бүлгийн зүйлүүд бүхэлдээ 2 7,8,9	Эдгээр зохицуулалтууд хэрэгжсэнээр хуулийн зорилт хангагдаж байгаа эсэхэд судлах
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн бүх зүйл, заалт	Ойлгомжтой байдлыг шалгах
3	Харилцан уялдсан байдал	Хуулийн төслийн бүх зүйл, заалт	Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судлах

### 1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

Хуулийн төслийн дээрх зүйл, заалтуудын хэрэгжилтийн үр дүнг судалж үзэхэд үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төслийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 7.1 - 7.3, 8 дугаар зүйлийн 8.1 - 8.10.4, 9 дүгээр зүйлийн 9.1 - 9.9 дүгээр заалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, хуулийн төслийн зорилтыг хангах боломжтой байна.

### 2. Ойлгомжтой эсэх:

Энэхүү шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд тавигдсан нийтлэг шаардлагад заасан асуултуудад хариулт өгөх замаар тодолрхойлов.

	Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх
1	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх:	Шаардлага хангасан.
2	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх:	Шаардлага хангасан.
3	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх:	Шаардлага хангасан.
4	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх:	Шаардлага хангасан.
5	Зүйл, заалт нь хоорондоо зөрчилгүй байх:	Шаардлага хангасан.

6	Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх:	Шаардлага хангасан.
7	Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн гнийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх:	Шаардлага хангасан.
8	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нэхцэл байдал, нийгмийн эрх зүйн этгээдийн чиг, үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам:	Шаардлага хангасан.
9	Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана:	Шаардлага хангасан.
10	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог ашиглана:	Шаардлага хангасан.
11	нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх:	Шаардлага хангасан.
12	үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч, тодорхой ойлгоход хялбараар бичих:	Шаардлага хангасан.
13	хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх:	Шаардлага хангасан.
14	жинхэнэ нэрийг ганц тоон дээр бичих:	Шаардлага хангасан.

Хуулийн төслийн зохицуулалт нь дэвшүүлсэн зорилго, зорилт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжтой, төслийн агуулга нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд ойлоход хялбараар томьёологдсон байна.

### 3. Харилцан уялдсан байдлыг хангасан эсэх:

Хуулийн төслийн харилцан уялдсан байдлын үнэлгээг дараах асуудлууудад хариулах замаар хийллээ.

	Асуулт	Хариулт	Үнэлгээ
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Нийцсэн. Шаардлага хангасан байна.
2	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Нийцэж байна.
3	Хуулийн төслийн зүйл заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Нийцэж байна
4	Хуулийн зүйл заалтыг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Тодорхой тусгасан байна
5	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Шаардлагатай зохицуулалт хийгдсэн байна.
6	Хуулийн төсөлд төрийн байгууллагын	Үгүй	Давхардал байхгүй байна

	гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх		
7	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой
8	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй
9	Хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллашгааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй
10	Хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй
11	Хуулийн зүйл заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төслийн зохицуулалтад хамааралгүй
12	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.
13	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Шууд хамааралтай зохицуулалт байхгүй

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу шинжилгээ хийж үзэхэд Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн зүйл заалт нь хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт байхгүй, шаардлага хангаж байна.

## ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн үр нөлөөг зорилгод хүрэх байдал, ойлгомжтой байдал, харилцан уялдсан байдал гэсэн гурван шалгуур үзүүлэлтээр тооцож үзэхэд хуулийн төслийн зохицуулалт нь дэвшиүүлсэн зорилго, зорилт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжтой, төслийн агуулга нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд ойлгоход хялбараар томьёологдсон, хуулийн зүйл заалт нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцсэн байна гэж дүгнэж байна.

Иймээс уг хуулийн төслийг батлуулах боломжтой гэж үзэж байна.

----- оОо -----